



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/636

Хэрлэн сум

Сэцэн ханы тамга, Сэцэн ханы тамганы
хайрцгийг зөөж, тээвэрлэхэд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингис хаан музейгээс Сэцэн ханы тамга, Сэцэн ханы тамганы хайрцаг 2 ширхэг үзмэрийг аймгийн Музейн байр луу буцаан зөөж, тээвэрлэх зардалд 1,630,800 (нэг сая зургаан зуун гучин мянган найман зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-т гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны... дүгээр сарын...-ны дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

1. Шатахууны зардал

№	Машины марк	Туулах нийт зам	100 км-т	Нийт км-т	Шатахууны үнэ	Нийт үнэ
1.	Фургон авто машин	700 км	20 л	140 л	2520 (А92)	352800

2. Томилолтын зардал

№	Явах хүмүүсийн албан тушаал	Нийт Хоног	1 хоногийн томилолт	Нийт зардал
1.	Ажлын хэсгийн ахлагч, Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн	1	142000	142000
2.	Музейн захирал	1	142000	142000
3.	Бүртгэл мэдээллийн санч (Хөдлөх Дурсгалын)	1	142000	142000
4.	Тагнуулын хэлтсийн ахлах ажилтан	1	142000	142000
5.	Цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгч	1	142000	142000
6.	Сан хөмрөгч	1	142000	142000
7.	Эрдэм шинжилгээний ажилтан	1	142000	142000
8.	Арга зүйч	1	142000	142000
9.	Харуул / жолооч/	1	142000	142000
Нийт				1,278,000

№	Зардлын нэр	Мөнгөн дүн
1	Шатахууны дардал (Фургон авто машин)	352800
2	Томилолтын зардал	1,278,000
НИЙТ ДҮН		1.630.800